



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/245

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт цаг агаарт зориудаар нөлөөлөн хур тунадасыг нэмэгдүүлэн хөрсний чийгийг сайжруулах ажиллагааг дэмжих зардалд зориулан нийт 15 000 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 15 000 000 төгрөг /арван таван сая/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8/04 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан аймгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт хөтөлбөрийн арга хэмжээний жагсаалтын 1.5-д тусгагдсан “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг дэмжих” арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Гантөмөр/ нарт зөвшөөрсүгэй.

3. “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг дэмжих” зардлыг хавсралтаар баталсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 01215

Zax A/245 Ch